



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 09 сарын 19 өдөр

Дугаар А/593

Булган сум

Төсөл сонгон шалгаруулах дэд
хороо байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Засгийн газрын 2020 оны 113 дугаар тогтоолоор батлагдсан “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, дамжуулан зээлдүүлэх, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2025 оны 05 дугаар сарын 16-ний өдрийн А/240 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох төсөл сонгон шалгаруулах дэд хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дэд хорооны дарга: Г.Гантулга (Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Гишүүд: Н.Пүрэвсайхан (Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга)
А.Пүрэвжаргал (Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, төсөл хариуцсан мэргэжилтэн)
Т.Жаргалант (Хөдөө аж ахуй хоршоологчдын холбооны тэргүүн)

Нарийн бичгийн дарга: Д.Оюунгэрэл (Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимын Булган аймаг дахь салбарын дарга)
Г.Ганжаргал (Баялаг бүтээгчдийн холбооны гишүүн)
Д.Эрдэнэтуяа (Малзүйч үржүүлэгчдийн холбооны гишүүн)
Б.Батбаяр (Хүнс, хөдөө аж ахуйн газрын Хөнгөн болон жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн)

2. Төсөл сонгон шалгаруулалтыг холбогдох хууль, журмын дагуу ил тод, нээлттэй зохион байгуулж, тайлагнахыг дэд хорооны дарга (Г.Гантулга)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР



6325010816